

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ**  
**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ**

№18/479

ШУС, НУС

2017

**ДОНОЙН ЦЭДЭН-ИШИЙН ДОТООД ЕРТӨНЦӨӨР АЯЛАХУЙ**

("Аян зам: бодол эргэцүүлэл" номын шүүмж)

Т.Баасансүрэн\*

\* "Улаанбаатар Эрдэм" их сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн эрхлэгч, доктор(Ph.D), профессор

**Түлхүүр үг:** аян замын тэмдэглэл; аян замын тэмдэглэлийн сэдэв, зорилго; зүйрлэл харьцуулалт, дүрслэл; сэтгүүлчийн ур чадвар

**М**онголын сэтгүүл зүйн нэртэй том төлөөлөгчийн нэг, МУСГЗ, сэтгүүлч Донойн Цэдэн-Иш "Аян зам: бодол эргэцүүлэл" шинэ номоо уншигчдын гарт хүргэв. Аян замын тэмдэглэлүүдээс бүтжээ. Цаг хугацааны хувьд өнгөрсөн зууны ерээд оноос өнөөг хүртэлх, орон зайн баримжаа нь бөмбөрцөг дэлхийг бүсэлхийгээр нь бүтэн тойрсон сэтгүүлчийн бичлэг-тайлан байна. Дотроо 43 тэмдэглэлийг багтаажээ.

Д.Цэдэн-Иш нь Монголд чөлөөт хэвлэлийг үүсгэн төлөвшүүлэх үйлсэд хүчин зүтгэж явсан зүтгэлтний нэг гэдгийг сэтгүүл зүйн салбарынхан сайн мэднэ. Ерээд оны шилжилтийн жилүүдэд Монголын хэвлэлийн хүрээлэнгийн захирлаар үр бүтээлтэй ажиллаж байв. "Ардын эрх" бас "Өнөөдөр" сониныг үүсгэн байгуулагдахаас нь эхлээд хүчин зүтгэлцсэн нэгэн. Өөрийн шилдэг нийтлэлүүдээ дээрх сонинуудаар дамжуулан уншиг-

чиддаа хүргэж Монголын ард түмний танил болсон сэтгүүлч.

Юмжаагийн Цэдэнбал, түүний тойрон хүрээлэгчдийг нийгмээрээ шүүмжилж "үзэн ядаж" туйлширч байхад Д.Цэдэн-Иш МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүдтэй бараг бүгдтэй нь нэгбүрчлэн хуучилж Монгол Улсын шинэхэн түүхэнд нэн хэрэгтэй үүх түүхийг яриулж тэмдэглэн үлдээж чадсан байдаг юм. "Дамдинжавын Майдар: Хэвлэл мэдээллийнхэнд би итгэдэггүй", "Түмэнбаярын Рагчаа: Улстөрийн дүгнэлтийг ингэж өгөхгүй л дээ", "Дэмчигийн Моломжамц: Би Цэдэнбалд биш улс орондоо алба хааж явлаа", "Жамбын Батмөнх: хангамж их авч байжээ гэвэл би зөвшөөрнө" ... зэрэг алдарт ярилцлагууд бол түүний бүтээлүүд. "Монголын шилдэг нийтлэл" цуврал 99 ботийн 32 дахь ботийг түүний нийтлэлүүдээр түүвэрлэн гаргасан юм. Зохиогч дээрх ярилцлагуудаа "Хуучин нам төрийнхөн хуулийн өмнө" гэж тусгайлан гарчиглаад өөрийн ботьдоо түүвэрлэн оруулжээ. Тэр өөр ч олон сонин содон хүмүүстэй, тухайлбал П.Жасрай, Ц.Гомбосүрэн, Ж.Гомбожав, Р.Гончигдорж, Д.Ган-

болд, Ч.Пүрэвдорж, Д.Цахилгаан, П.Үржинлхүндэв, тэр ч битгий хэл оросын нэрт зохиолч П.Распутин, Е.Евтушенко, Ч.Айтматовтой хүртэл халуун дотно яриа өрнүүлж явсан туршлагатай сэтгүүлч. Залуу, дунд үеийн сэтгүүлчид бол түүнийг ярилцлагын шилдэг мастерын нэг гэж боддог байх. Тэр үнэн.

Түүнчлэн Донойн Цэдэн-Иш бол манай аян замын тэмдэглэлийн нэг гол төлөөлөгч юм. Үүний тод баталгаа нь “Аян зам: бодол эргэцүүлэл” бүтээл нь болно. Уг номд “Их, бага Шанхай”, “Төлөг, хужаа л гэх юм. Бид өөрсдөө хэн бэ?”, “Аугаа их Ким Ирийнхний нутгаар”, “Экс Ерөнхий сайдыг ч, экс тэргүүн хатагтайг ч их Америк ивээж л байна”, “Монгол удмын хаан хатандаа зориулж Таж Махалыг босгожээ”, “Хоцрогдсон гэх Балба ч холоо явчихаж”, “Ертөнцөд Хятадгүй юм гэж байхгүй болов”, “Будапешт бас нэгэн дурсамж”, “Миланы аялал ба өмнийн сургамж”, “Марко Полотой, бас Леонардо Да Винчитэй Венец”, “Лувр, Эйфель, Дарь Эх бүгд л гайхамшиг”, “Усан бороотой Осака, Киотогийн битүүн”, “Эзэн хаан Адулядетийн Тайланд орноор”, “Хамаатан садантай, бас танил нөхөдтэй Вьентьян”, “Сайгон буюу өнөөгийн Хо Ши Мин”, “Бөмбөрцгийн нөгөө бөөрөн дэх Куба”, “Ленин багштай, Сталинтай, бас Путинтэй Москва”, “Ниагарын хүрхрээ”, “Дэлхийн нийслэл Нью-Йорк” .... зэрэг тэмдэглүүд нь орсон байна.

43 тэмдэглэл гэж би өмнө нь онцолсон. Тэдгээрээс 19 тэмдэглэлийн гарчгийг зориуд нэрлэлээ. Бөмбөрцөг дэлхийн улс орнуудыг бүсэлхийгээр нь бүтэн тойрчээ гэж эхэнд хэлснийгээ батлахын тулд тэр. Бүх тэмдэглэлд нь шинжилгээ хийж үнэлэлт дүгнэлт өгч ярина гэвэл хэдэн арав, зуун хуудас

болох нь лавтай. Томоохон судалгааны ажил болно. Түүнийг залуу эрдэмтэд, хойч үеийн судлаачдад ацаглаж үлдээгээд өөрийн санаа бодлоо товч төдий тоймлон базаж илэрхийлье.

**Д**.Цэдэн-Ишийн аян замын тэмдэглэлүүдэд Монголын бусад нийтлэлчдийн бүтээлд төдийлөн элбэг ажиглагддаггүй нэг онцлог, гойд ялгаа байна. Үүнийг онцгойлж ярихыг хүслээ. Зохиогч “Төлөг, хужаа л гэх юм. Бид өөрсдөө хэн бэ?” тэмдэглэлээ Вьетнам, Хятад, Ардчилсан Солонгосоор явж ирээд бичжээ. Тэрбээр нөгөө “социализмаа” барьж дуусаагүй төлөг, хужаа, ядуу дорой солонгосууд маань үг ярих биш үйл бүтээж байна гэж онцлоод түүнийгээ “Төлөг хэмээх Вьетнам маань түмпэн сав гаднаас зөөхөө болиод уджээ. Өмсөх зүүх, идэж уухаа өөрсдөө шийддэг болчихож. Унаа хөсгөө ч өөрсдөө хангаад эхэлж. Алдарт “Мерседес Бенз”, “Форд”, “Тоёото”-гийн хөрөнгө Вьетнамд аль хэдийнэ ороод ирж” гэж уншигчиддаа сонирхуулсан бол “Аугаа их Ким Ирийнхний нутгаар” тэмдэглэлдээ хот байгуулалт, мод зүлэг, ногоон байгууламжийн хувьд монголчууд бид хойд Солонгосоос мөн ч хол хоцорчээ гээд “Үзэж харах үзмэр музей, түүх дурсгалт газар, додомдож тордсон нь биднийг бүр ч дагуулахгүй. Кымсусаны бүс хэмээх цогцолбор тэдний бахархал, гадныхны гайхашрал. Тэсон уулан дахь хувьсгалчдын оршуулгын цэцэрлэгт хүрээлэн, алдартнуудын хөшөө дурсгалыг хагас өдөр үзэв. Цэцэг ногоо, ой мод, уран баримал, ур ухааны бүхэл бүтэн цогцолбор юм. Хэдэн шат өгсөөд л хэсэг үзмэр. Уулын хормойгоос шатаар өгсөнгөө хөшөө дурсгалуудыг үзнэ. Солонгосын хойгийн дайны баатрууд, домогт жанжнуудын зэсээр бүрсэн хүрэл баримлууд...

Цэрэг дайны түүхэн үйл явдлыг гайхалтай дүрсэлсэн баримал байгууламжийн бүхэл бүтэн чуулбар ч байх юм. Ур хийц, өнгө зүс, донж нь нүд баясаж, сэтгэл татам. Тэсон уулын оройд гарахад шат ч дуусна, үзмэр ч дуусна...

Ууж идэх, наргих цэнгэх баар сав, өмсөх зүүх эрээн мяраанаар Хойд Солонгосчуудыг бид хол хаячихаж. Харин барьж байгуулсан, хийж бүтээснээрээ их л хол хоцорчихож гэж санагдсан шүү” гэжээ. Үүнийг уншаад уншигч танд эрхбиш нэг зүйл бодогдох нь лавтай.

**Д**.Цэдэн-Иш урд хөрш Хятад орны тухай ахин дахин бичжээ. Тэр бүгддээ нэгийг хэлж, нөгөөг ухааруулах гэж зорьсон нь аяндаа мэдрэгдэх аж. Төлөөлүүлж ганцхан тэмдэглэлээс нь иш татъя. “Ямар Монголыг дэлхий сонирхох вэ?” тэмдэглэлдээ “Хятадад аялах жуулчдын тоо жил бүр нэмэгдэж энэ онд /2010/ 48 саяд хүрээд байгаа гэнэ. Мэдээж Өвөр Монголд энэний 2 сая гаруй нь байж магад. Манай Монголд хагас сая хүрдэг билүү, үгүй юу гэдэг асуулт гарна даа. Урд хөрш маань энэ бүхнийг бодлого, чиглэлтэйгээр хөгжүүлж байгаа нь илт. Ордост аялахдаа үүнийг нь илүү их мэдэрлээ. Эзэн Чингист эднийхэн илүү их ач холбогдол өгч, илүү их хөрөнгө заржээ.

Манайхныг мунгинаж байтал урд хөршийн овсгоотнууд маань өвөрлөгчийнхөө нэрээр дэлхийг татаад байх шиг. Хөрш Япон, Солонгосууд гэлтгүй, Европ, Америкийнхэн Чингисийн онгон үзэхээр Өвөр Монгол руу цувах болсон гэнэ. Морьтон баатруудын дүр төрх сүрлэг, бас тэгээд өөр өөр. Нүдэнд үл анзаарагдам хад чулуунуудын дор дуу өсгөгч хэд хэдийг цувуулан байрлуулсан байх агаад түүгээр нь баатруудын

уухайлах, тулалдах чимээ хаа сайгүй сонсогдох нь сонирхолтой. Үнэхээр 13-р зуунд ирчихсэн, их тулааны хөлд орчихсон юм шиг сэтгэгдэл төрүүлэх юм. Баатрууд, морь, үхэр тэрэг бүгдийг ширмээр цутгажээ. Урт өндөр нь дөрөв таван метр, жин нь гурваас дөрвөн тонн гэнэ...

Шанхай, Хөх хот, Ордосынхоо аяллаас бид нутагтаа ирж явна. Онгоц удахгүй газардана. Чанга яригчаар үйлчлэгч бүсгүй цангинасан сайхан хоолойгоор “Хүндэт зорчигчид оо, манай онгоц Чингис хаан олон улсын нисэх буудалд удахгүй газардана” гэж монгол, англи хэлээр омог бардам зарлаж байна. Эзэн хаантай тэр энэ гээд холбочихоор ганц хөшөө, зураг хөрөг ч байдаггүй хэрнээ ингэж л хий дэмий цээжээ дэлдэх юмдаа манай нисэхийнхэн гэж бодогдож байна. Чингис зочид буудлыг бас саналаа. Чингис гэж нэршихээр юм тэнд юу байдаг билээ, сана даа таминь. Уг нь нэг сайхан хөшөө байж болмоор доо...

Манай улсад сууж байсан Хятадын Элчин сайд Гао Шумао хэмээх эрхэм 2004 онд “Азийн зуун” сонины эхний дугаарт өгсөн нэгэн ярилцлагадаа “Монгол бол Хятадын 56 үндэстний нэг бүрэлдэхүүн юм. Чингис хаан бол дэлхийд алдаршсан Хятадын үндэсний баатар мөн” гээд хэлчихсэн байсан. Онгон, Ордосын хөгжил, байр байдал бас л энэ тал руу бодлоготойгоор чиглэж байх шиг. Өөрийн юмыг өөд нь татаад авч чадахгүй болохоор өрөөл бусад нь эзэмшээд авчихаж байгаа нь тэр юм биш үү? Ухаан нь богино, шунал нь урт манай удирдагчид “Хөрөнгө мөнгө байхгүй, ядуу зүдүү л...” гэх байх даа. Мунхаг амлалтдаа тарааж байгаа хэдэн тэрбум чинь Ордосын онгоны дайтайг Хэнтий Хан нутагт нь, Хэрлэн мөрнийх нь хөвөөнд

сүндэрлүүлчихэд хүрэлцэхээр байсан” хэмээжээ.

Вьетнам, Ардчилсан Солонгостой Монгол Улсаа харьцуулж жишсэн хөгжлийн ялгаа хажуухан талын Өвөр Монголын Онгодын жишээн дээр бүр ч илүү, хурц тодоор мэдрэгдэж байна. Хөрш зэргэлдээх Их Хятадын түрэмгий бодлого, өмхий далд санаатай холбож өгүүлээд өөрийн улсын шуналт мунхаг удирдагчдын хэтэрхий богино ухааныг хурцаар шүүмжилжээ.

Сэтгүүлч Д.Цэдэн-Иш таван тивийн олон улс орноор аялан жуулчилжээ. Үзсэн харсан бүхнээ эргэцүүлэн бясалгаж, тэр бүгддээ эх орон, улс орныхоо хөгжил дэвшилттэй холбон өөрт төрсөн сэтгэгдлээ уншигчидтайгаа харамгүй хуваалцсан байна. Харьцуулан жишиж би, бид хүн төрөлхтний хөгжил дэвшлийн хаахнуур явж байна, юун дээр алдав, юун дээр хожив гэдгийг тал бүрээс нь эргэцүүлэн бодол-хийлжээ. Чухам үүнд түүний тэмдэглэлүүдийн гол үнэ цэнэ оршино. Ийм бодол эргэцүүлэлгүй нэг ширхэг ч тэмдэглэл алга. Бичлэг бүрээс нь шинэ санаа, сэргэг мэдрэмж нэвт гэрэлтэж байна. “Аян зам: бодол эргэцүүлэл” номын амт, шимт нь үүнд агуулагдаж байгаа бөгөөд эл шинж чанараараа Монголын бусад нийтлэлч-

дийн тэмдэглэлүүдээс эрс ялгарч буйг онцгойлон тэмдэглэе.

“Магдебургийн үеэл Оюунаа ба Никарагуа хүргэн Ферес Тито” хэмээх тэмдэглэлдээ Д.Цэдэн-Иш Германы Магдебург хот үүсэн байгуулагдаад 1200 жил болсныг тэмдэглээд “Хотын дундуур алдарт Элба мөрөн нь урсана. Мянган жил Элба мөрний ус урсгал

нэгээхэн татарч тасарсангүй, харин ч орчин үеийн олон арван усан онгоц үүгээр хөвж ачаа бараа, аянчин жуулчдыг зөөсөөр байна. Манай нийслэл Хүрээ гурван зуугаад жилийн өмнө арвин их устай хатан Туулынхаа хөвөөнд ой мод, цэцэг ногоо нь дэлгэрсэн Богд хан их уулынхаа дунд ханаа шийрлэн өргөө гэрээ барьж байсан түүхтэй гэдэг. Бараг дөрөв дахин дүү настай мөртлөө хатан Туулаа ширгээж Хан Богдоо нүцгэрүүлэ-

хийн даваанд хүрч, нөгөө залуу нийслэл маань үхэл мөхлийн заагт ирчихээд байна шүү дээ” хэмээн Элба мөрнийг жараадхан жилийн өмнө сал урсгаж байсан хатан Туултайгаа харьцуулан жишиж халагласан нь герман ба монгол хүний хүрээлэн байгаа байгаль орчинд хандах хандлага өдөр шөнө шиг эрс тэс ялгарч байгааг барин тавим үнэнээр дүрслэн үзүүлжээ гэлтэй.

«

*Сэтгүүлч Д.Цэдэн-Иш таван тивийн олон улс орноор аялан жуулчилжээ. Үзсэн харсан бүхнээ эргэцүүлэн бясалгаж, тэр бүгддээ Эх орон, улс орныхоо хөгжил дэвшилттэй холбон өөрт төрсөн сэтгэгдлээ уншигчидтайгаа харамгүй хуваалцсан байна. Харьцуулан жишиж би, бид хүн төрөлхтний хөгжил дэвшлийн хаахнуур явж байна, юун дээр алдав, юун дээр хожив гэдгийг тал бүрээс нь эргэцүүлэн бодолхийлжээ. Чухам үүнд түүний тэмдэглэлүүдийн гол үнэ цэнэ оршино. Ийм бодол эргэцүүлэлгүй нэг ширхэг ч тэмдэглэл алга. Бичлэг бүрээс нь шинэ санаа, сэргэг мэдрэмж нэвт гэрэлтэж байна*

»

“Будапешт ба бас нэгэн дурсамж” тэмдэглэлдээ Д.Цэдэн-Иш Унгарын нэг дэлгүүрт аялагч нөхөдтэйгөө хамт орж арилжаа наймаа хийснээ “манайхны хүслэн болсон дэлгүүр хоршоо хэсэх ажил эхэллээ. Хэсэх ч гэж дээ бид хэдийг ганцхан том дэлгүүрт оруулаад л “яргуйд цадсан ямаа” шиг болгож орхих нь тэр. Ёстой л ногоон хурганы арьс, нохойн битүү туурайнаас бусад нь тэнд байлаа. Орны өмнө тавьчихаар жижгэвтэр хивс нэг, эхнэртээ ямаан хилэн пиджак, хүүдээ малгай өмд, өөртөө судалтай цамц, зангиа, амьтан хүнд өгөх бохь чихэр мэтийг аваад хэдэн форинтоо дуусгачихлаа. Жил гаруйн өмнө Унгарын Ардын хяналтын төлөөлөгчдөд үйлчилж дэлгүүр хоршоонд оруулж явахдаа юун ч цамаан нөхдүүд вэ гэж тэднийг зэмлэж явснаа энд эргэн санахад хүрэв” гэжээ.

Монголд айлчилсан унгар нөхөд баахан мөнгөө төгрөг болгож солиулсан юм байна. Тэгээд Д.Цэдэн-Ишийг дагаад дэлгүүрджээ. Гайхалтай нь тэд нэг их юм худалдаж авсангүй. Үнэнийг хэлэхэд тэнд унгарчуудад авах зүйл байсангүй. Үйлчлэгч Цэдэн-Иш зочдынхоо төгрөгийг эргүүлж гадаад валют болгох гэж баахан ядарч зүдэрсэн юм байна. Энэ бол социализмын үеийн монгол дэлгүүрийн үнэн бодит дүр төрх. Дараа жил нь мань хүн Будапештэд очоод ганцхан дэлгүүрт хамаг мөнгөө барж “яргуйд цадсан ямаа”-тай адилхан болсноо тэмдэглэж бичсэн нь энэ. Бас л харьцуулан жишжээ.

Цааш нь тэрбээр Будапештийн дуурийн театрт эхнэртэйгээ хамт “Тоска” дуурь үзсэнээ өгүүлэхдээ өлгүүрт хувцсаа өлгүүлэхээс эхлээд завсарлагаар цай кофе, хундага дарс авч уух санаатай Европын гол мөнгөн

тэмдэгт еврогоор үйлчлүүлэх гээд бараагүй. Унгарчууд урдаас нь зөвхөн форинтоор наймаа хийдэг гээд хөдлөөгүй тухай бичжээ. Манайд америк ногооныг, тэр битгий хэл урд хөршийн юанийг хаана л бол хаана авна шүү дээ. Эл бяцхан жишээнээс унгар, монгол хүний сэтгэхүйн том ялгаа, эдийн засгийн болоод улстөрийн тусгаар тогтнолын талаарх ойлголтын зөрүү тод ажиглагдаж байгаа юм.

Энэ бүхнийг нэн гярхайгаар олж харан ажиглаж, сэтгүүлчийн соргог мэдрэмжээр мэдрэн, улмаар цааснаа буулгаад бодлогошрон бясалгасан нь онцгой сонирхол татаж байгаа болно. Үүнийг би хувьдаа Монголоо голж муучлах гэсэн санаа гэж огтхон ч бодохгүй байна. Харин ч уншигчдыг улам ухааруулж урагшлан хөгжиж дэвшихийг уриалсан өөдрөг гэгээн үзэл санаа гэж олзуурхан хүлээж авч байна. Энэ бол нийтлэлчийн дотоод ертөнц гадагшаа дэлбэрэн гарч буйн нэг илэрхийлэл юм. Монголоо гэсэн, монголчуудаа гэсэн үнэн зүрхнийх нь үг. Хөгжил дэвшлийн мухардалд орсон Монгол Улс, алт сандайлсан гуйлгачин монголчуудын цаашдын хувь заяанд сэтгэл шимшрэн шаналж, зүрх өвдсөн сэтгүүлчийн дэлдэж анхааруулсан харанга. Дэлхийн бусад улс орон, хар, шар, цагаан үндэстэн ястнуудын сайн сайхныг, ур чадал, арга ухаан, хөдөлмөрч чанар, хөгжил дэвшлийн нууцыг монгол нутгийнхаа газар шороонд авчирч суулган нутагшуулахыг хүссэн иргэнлэг нийтлэлч Цэдэн-Ишийн хүсэл эрмэлзэл. Чухам үүгээрээ түүний аян замын тэмдэглэлүүд бусдаас онцгойрон ялгарч байгааг дахин хэлье.

Аян замын тэмдэглэл нь сэтгүүл зүйн бусад төрөл, зүйл дотроо үндсэн

агуулгыг илэрхийлэн гаргах дотоод боломж, орон зай, цаг хугацааны хувьд эрт эдүгээг эргэцүүлэн нэгтгэж харьцуулан жиших чадамж, уншигчдыг урхидан татах ур хийц, дүр дүрслэлийг чөлөөтэй ашиглах, маневарлах чанараараа гаргууд бичлэгийн торгомсог хэлбэр юм. Монголын сэтгүүл зүйд олон зуун жилийн өмнөөс, бүр “Монголын нууц товчоо” хөлгөн их судрыг бүтээх найман зууны тэртээгээс, магадгүй түүнээс ч өмнөх цаг үед үүсэн бүрэлдээд улам улмаар боловсронгуй болж төгс хөгжиж төлөвшсөн бичлэг бол аян замын тэмдэглэл. Бичлэгийн эл хэлбэрийг Донойн Цэдэн-Иш муугүй эзэмшиж чадсан нь “Аян зам: бодол эргэцүүлэл” хэмээх түүний шинэ номноос тод харагдаж байна.

**Н**ийтлэл зүйн уран яруу хэл хэллэг, тансаг сайхан дүр дүрслэл эл номд цөөнгүй тааралдах аж. Жишээ нь “Хасах хорин хэмтэй, цасаар шуурсан Улаанбаатараас өглөө гарсан биднийг нэмэх арван хэмтэй зөөлөн бороо шивэрсэн ногоон Токио угтав” /”**Юугаараа баян түүгээрээ... гэдэг үг бий**”/. “Солонгосууд нэгэн жигдийн бараандуу хувцас өмсөх юм. Царай нь ч бүүдгэр, гунигтай талдаа” /”**Аугаа их Ким Иррийнхний нутгаар**”, “Гурван арван жилийн өмнөхөндөө бол гурав дөрвөн тэмээ хөтөлсөн, ус өвс хайсан нүүдэлчин төдий л ард түмэн байсан гэдэг эднийхэн. Өнөөдөр харин бидний гэлтгүй тив тивийнхний анхаарал татсан хөгжингүй гүрэн, аз жаргалтай ард түмэн хэдийнээ болжээ. Элчилгүй элсэн говь нь эрдэнэс баялаг болох газрын тосоо тэдэнд харамгүй хайрлажээ. Гудамжаар нүд, хөмсөг болон гэрэлтсэн цагаан царайтай торгон цагаан нөмрөгтэй гунхсан эрчүүд харц дээгүүр, нуруу цэх ихэмсэгхэн

алхалцгаана” /”**Баян орны жаргалтай өнгө төрх**”/, “Манайхан хөрч хөлдчихгүйхэн шиг яаж өвөлжинө гэж зовлон болдог шиг Делийнхэн тав зургаан сарын 50 хэмд яаж хайлчихгүйхэн шиг зусна даа гэж зовцгоож байна. Сэнс, хөргүүр ажиллахгүй нэг хоёр цаг болбол ер нь урсах бололтой юмбилээ” /”**Монгол удмын хаан хатандаа зориулж Таж Махалыг босгожээ**”/, “Газар нутгийн хувьд манайхаас арав дахин бага, хүн ам нь харин арав дахин их, жилдээ хэдэн саяар жуулчин хүлээн авдаг нь манайхаас бас л арван хэд дахин их, ийм л орон” /”**Хоцрогдсон гэх Балба ч холоо явчихаж**”/, “Яг дээр чинь тэнгэр дуугараад л, цахилгаан цахиад л, тэгснээ бороо зөөлөн шивэрч Шанхайн өглөө эхэлж байх. Шанхайн үзэсгэлэнт хос залуус шүхэр дэлгэн гүйлдэнэ. Бороо зогсч, солонго татна, өглөөний нар мандана. Хотын гэгээлэг амьдрал, хөл хөдөлгөөн эхэлнэ. Хүмүүсийн царай баяр жавхлангаар дүүрэн” /”**Ямар Монголыг дэлхий сонирхох вэ?**”, “Би гэдэг хүн тавь гарсан хойноо Хяргас нутаг руугаа, Хяргас нуур луугаа гэр бүлийнхэнтэйгээ явах минь олшров. Энэ жилийн хувьд найз нөхдөө дагуулаад дөрөв таван гэр бүл буюу 20-уулаа нутгийн зүг хөдлөв. Тэдний олонх нь Ховд, Говь-Алтай, Улаанбаатарын угшилтай хүмүүс л дээ. Бид нэгэн цагт Ази, Европын хэд хэдэн орноор хамтдаа явж жуулчилж Арабын тэнгис, Энэтхэгийн далай, Шар тэнгисийн усанд хөл дүрж хөвж сэлж явцгаалаа. Би тэдэнд, бас таньдаг таньдаггүй олон хүнд ганц л үгийг хэлж явдаг байсан. “Нам засгийн буянаар бишгүй л нуур далай үзлээ. Хар далайн эрэгт амарч, Хавайн тэнгист сэлж, Арабын хойг, Энэтхэгийн далай, Балтын тэнгис, Номхон далай

энэ тэр гээд үзээгүй, очоогүй далай тэнгис ховорджээ. Гэхдээ Хяргас нуур шиг гайхамшиг тэр дунд байсангүй гэж ярьдаг юм.

Цэвэр тунгалаг, бүлээн дулаанаараа, бас тогтоцоороо, зөөлөн элс хайргаараа Хяргас нуур үнэн гайхамшиг. Эрдэс бодисоороо биеийг чинь савандаад гаргана” /”**Сэтгэлд уяатай нутаг ус минь**”/ гэх зэрэг нүд булааж, сэтгэл баясгасан үг өгүүлбэр цөөнгүй тааралдаж байна.

**А**дилтгал зүйрлэл, харьцуулал тодотголыг чадмаг ашиглажээ. Ардчилсан

Солонгосын хүн ардын тухай өгүүлэхдээ нэгэн жигдийн бараандуу хувцас өмсөх юм. Царай нь ч бүүдгэр, гунигтай талдаа гэж дүрсэлсэн бол Арабын Эмиратын Дубайд хөл тавиад олж үзэж олзуурхаж ажигласнаа гудамжаар нүд, хөмсөг болон гэрэлтсэн цагаан царайтай торгон цагаан нөмрөгтэй гунхсан эрчүүд харц дээгүүр, нуруу цэх ихэмсэгхэн алхалцгаана гэж зурагласан байна. Хүнд хэцүү ядруу аж амьдралыг туулж гатчиж яваа хийгээд аз жаргалтай баян тансаг улс орон-ази ба араб тивийн хоёр ард түмний тухай ингэж хэлжээ. Өмссөн зүүсэн хувцас хунар, өнгө төрхөөр нь харьцуулан жишиж сөргөлцүүлэн дүрсэлж гаргасан нь тун оносон байна. Энэ бол туршлагатай нийтлэлчийн ур чадварын тод илрэл мөн.

Хасах хорин хэмээр хүйтэрч цас шуурсан Улаанбаатараас өглөө эртлэн мордоод үд дундын алдад нэмэх арван хэмийн дулаахан бороо шивэрсэн ногоон Токиод хөл тавихад уран бүтээлч хүнд эрхбиш нэг юм бодогдолгүй яах билээ. Д.Цэдэн-Иш өөрийн тэмдэглэлээ байгаль дэлхийн энэхүү өнгө хувирлыг зурж дүрслэн үзүүлсэн

өгүүлбэрээр эхэлснээрээ уншигчдын зүрхийг соронздон татаж чадаж байна. Энэтхэгийн тухай тэмдэглэлдээ ч бичлэгийн эл аргыг бас л чадмаг ашиглажээ. Энэтхэг болоод Вьетнамд олон жилийн өмнө аялахдаа би шөнө унтаад Алтайн мөнх цаст мөсөн оргилуудыг хүсэмжлэн зүүдэлснээ өөрийн эрхгүй эргэн дурсав. Тэдгээр улс оронд очсон монгол хүнд үнэхээр яг тэгж санагддаг юм билээ. Тэнгэр дуугаран цахилгаан цахиж, бороо шиврэн солонго татсан, үзэсгэлэнт хосууд нь шүхэр дэлгэн гүйлдсэн Шанхайн өглөөг ч зохиогч уран зураг адил гоёмсгоор дүрсэлжээ. Хяргас нуурын тухай нутгийн хүүгийн хэлсэн зүрх сэтгэлийн үгс онцгой сэтгэгдэл төрүүллээ. Хар далайн эрэгт амарч, Хавайн тэнгист сэлж, Арабын хойг, Энэтхэгийн далай, Балтын тэнгисээр тэнүүчилж, Номхон далайн эргийн ногоон хөвөөн дээр алсыг харж саравчлан зогсож буй монгол хүүд төрж өссөн нутаг ус, Хяргас нуур шиг нь гайхамшиг үгүй ажээ. Энэ санаа буюу эх оронч сэтгэл-гээ, өөрөөр хэлбэл Монгол Улсаа, монголчуудаа гэсэн зүрх сэтгэлийн халуун дулаан хаялга дуудлага Д.Цэдэн-Ишийн тэмдэглэл бүрээс нэвт мэдрэгдэж байна. “Аян зам: бодол эргэцүүлэл” номын амин сүнс нь энэ болой. Үнэхээрийн өндөр үнэ цэнэтэй ийм аугаа том агуулга санаа уг номонд алт адил тунаран шижиртэж хуран цогцолсон нь даанч бахдам тул үг үсэг, найруулга зүй зэрэг өчүүхэн зүйлээрөөлж баалж өөнтөглөн хөөцөлдөхийг урьтал болгосонгүйг эцэст нь өчсүү.

#### **Ашигласан бүтээлийн жагсаалт**

1. Д.Цэдэн-Иш. 2017. Аян зам: бодол эргэцүүлэл. УБ.
2. Д.Цэдэн-Иш. 2012. Монголын шилдэг нийтлэл. 32-р боть. УБ